

УДК 78 (517.3)

doi: 10.18101/978-5-9793-0054-2-2017-280-287

ОЙРД АЯЛГУУНЫ ТӨРӨЛ САДНЫ ДУУДАЛГЫН СОЕЛЫН АГУУЛГА

© Соел

преподаватель, Университет Внутренней Монголии КНР

КНР, г. Хух-Хот, ул. Западная Университетская

E-mail: 584981376@qq.com

Ойрд монголчуудын төрөл садны дуудалга нь үгийн сангийн бүрэлдхүүн хэсэг болохын сацуу хийгээд нийгэм соелын өвөрмөц онцлогийг илрүүлж чаддаг. Шинжианы ойрд монголчуудын төрөл садны дуудлагын утга нь бусад орны монголчуудынхаас ялгагдах өвөрмөц онцлог шинж ба соелын агуулгад задлалт хийлээ. Төрөл садны дуудалгын тогтолцоо бол нийгмийн байгуулал, ураг барилцах, хурмын ес, гэр бүлийн есны хувьсалтай харицуулбал нилээд тогтвортой байдаг. Гэвч эдгээр бүхний улирал хувьслыг тусгах түүхийн урт удаан явцад гүн гүнзгий соелын агуулгыг хуримтлууж ирсэн бөгөөд төрөл садны дуудлага болох нэг бүрийн утгийн онцлог шинжээр дамжин биелэлээн олдог. Тус өгүүлэлд ойрд монголчуудын төрөл садны дуудалгаас онцлогтой үгсийг сонгож, түүний соелын агуулгыг задалхаар дамжин ойрд монголчууд овгийн нийгмээс феодалын нийгэм, нийгэм журамт нийгэмд шилжих түүхэн үйл явц дахь улирал хувьслыг шинжилэв.

Түлхүүр үгс: Ойрд аялгуу; төрөл садны дуудлага; соелын агуулга; үгийн сан; шинж; түүх; феодал; нийгэм; гэр бүл; хувьсал.

Ойрд аялаганы авга ба ач гэх дуудлага нь доорхи хэд хэдэн төрлийн харьцааг илтгэдэг. Авга: эцгийн ах; эцгийн дүү; эцгийн ахын хүүхэд. Ач: эгчийн дүүгий хүүхэд; өөрийн ах дүүгийн хүүхэд; өөрийн хүүгийн хүүхэд. Ойрд монголчууд яагаад эцгийн ахын хүүхдийг авга, эцгийнх дүүгийн хүүхдийг ач гэдэг вэ? Энэ нь нийгмийн шалтгаантай байдаг. «Шинжианы чахарчуудын зан үйл» гэх номд «нэг аав ээжээс гарсан хүүхдийн ууган ах нь хэдэн үе дамжсан ч хамаагүй айлынхаа ах нь, дээлийн зах нь болж суудлынхаа эхэнд сууж, идэний дээжийг авж байдаг. Хойшид үр хүүхэд нь энэ айлыг (их айл), (ах айл), (ах өрх) гэж хүндэлдэг» [Гомбо, 2004, 5-р тал] гэсэн ба Баянголын хошууд монголчуудын дунд «насаар ах заяагаар ахыг гүйцэхгүй» гэж баяр еслолд бурханд цацал цацдаг нь эрхбиш төрлийн ахлагч байх хэрэгтэй. Ойрд аялганд «төрлөөн мартсан хөвгүүн муу, төрхмөөн мартсан хүүхэн муу» гэдэгчлэн энд хэлж байгаа төрлийн ахлагч бол нэг аавын олон хүүхдийн ууган ах жич түүний ууган үр хойчсыг зааж байдаг.

Эрдэмтэн Д. Гонгор «овгийн өв хөрөнгийг тухайн овог буюу эцгийн ууган хөвгүүн залгамжлаж, гал голомтыг сахин уламжилдаг» гэсэн ба «харц ардын хөвгүүд насныхаа эрмбийн дагуу эцгийн хөрөнгөөс хувь авах эрхтэй бөгөөд түүнийг (өмч хуваах) гэж нэрлэдэг», «ноед, тайж нар уг удмын нэрсийн хэлхээ гэрийн ургийн бичгийг нарийн чанд хөтөлж түүнийгээ мөрдөн аливаа асуудлыг шийдвэрлэж байв» [Гонгор, 1990, 250-р тал] гэжээ. Эрдэмтэн Х. Дамбижалсан «монголын жижиг гэр бүлийн эзэн нь эцэг хүн байсан. Эцэг бол гэр бүлд хамгийн хүндэтгэлтэй, эрх мэдэлтэй хүн билээ. Эцэг нь нас барсан бол ахмад хөвгүүн нь гэрийн эзнийг оролдог. Энэ нь аль эртнээс улам-

жилсан (хүн ахтай, дээл захтай) гэх хэв заншил билээ» [Дамбижалцан, 1995, 471-р тал] гэв. Овгийн байгууллаас боолын нийгэм, феодалын байгуулалт шилжих бүх явцад «ах» хүний эрх зэрэг, өв хөрөнгө нь бүр дүүгээс давамгайлж байсан байна. Энэ байдал «Монголын нууц товчоо»-д ч тусгагдсан байна. Жишээлвэл: Чингис хаан их монгол улсыг байгуулж хувь өмч хуваасан тухай 242-р зүйлд «улс хуваан зовогсод эх буюу хөвгүүдийн мину ах Зүчи бой, дүү нарын мину нялх одчихин бой» хэмээж эхэд Одчихины хувь хийгээд түмэн эрх өгөв... Зүчид есөн мянгад эрх өгөв. Цагаадайд найман мянгад эрх өгөв. Өгөөдөйд таван мянгад эрх өгөв. Тулуйд таван мянгад эрх өгөв...» [Элдэнтэй, 1986, 779-р тал]. Энд ахмад хөвгүүн Зүчийн олсон өмч эрх хамгийн олон болж байна.

270-р зүйлд хөвгүүний ах аялваас цэрэг арвин гарах [Элдэнтэй, 1986, 893-р тал] гэдэг нь мөн ч ахмад хөвгүүний өвлөх өмч ирх нь олон болхыг тусгаж байна. Мөн 275-р зүйлд Бат Хибхагчин аян дээрээс Өгөөдэй хаанаа элчнээс өчиж ирээрүн: Би эд бүхэн хөвгүүдийн ах нь болсон болж, нэгэн хоер аяга өтөг урид уув хэмээн натэр бүр, гүег хоер магуулж хурим үл хуримлан морилогдов [Элдэнтэй, 1986, 917-р тал]-д ах хүний эрх, байр суурь өндөр байхыг илрүүлж байна. Жишээлбэл: 23-р зүйлд «Эх юун Алонгуаг үгүй болсны хойно, ах нар дүү нар табуул адгуусан идээгээ хуваалдурун, Бэлгүнүдэй, Бөхнүдэй, бугу хадих, бухт шалж дөрвүүл авалцав. Буданчар мунхаг ботго буюу хэмээн ороо үл тоон хувь эс өгөв» [Элдэнтэй, 1986, 39-р тал]. 11-р зүйлд Дуваа сохор үгүй болсний хойно, дөрвөн хөвгүүд ину довон мэргэн авга юугаан үл болгоон доромжилж хагацак гэж нүүв» [Элдэнтэй, 1986, 21-р тал] зэргээс үзвэл овгийн байгууллын үед ах хүний өв хөрөнгө, эрх мэдэл, байр суурь нь өндөр байх ба түүний залгамжлагчид ч адилхан байр суурьтай байхыг мэдэж болно. Яг иймээс дүү Буданчарыг ургаас гаргах, авга Дуван мэргэнийг ураг үл болгон доромжилах хэрэг үүссэн байдаг.

Дээрхээс үзвэл «ах» гэх үг нь овгийн байгууллаас феодалын байгуулалт шилжих түүхийн урт удаан явцад, дан ганц насаар их гэх утгыг л биш харин өв хөрөнгөтэй, эрх мэдэлтэй, нэр хүндтэй, үе залгамжлах нийгмийн байр суурьтай гэх мэтийн далд утгыг агуулах болсон байна. Үгийн утгийн хөгжлийн явцад «ах» гэх үг олон салбар утгатай болжээ. Овгийн байгууллын үед овгийн бүх гишүүдийг хамааран захирдаг овог аймагийн түрүү, овгийн ахлагч буюу аймгийн ахлагчтай адилаар Шинжиан уйгар үндэстний өөртөө засах орны илийн хасаг үндэстний өөртөө засах жиугийн монгол хүрээ сияанд ах Суман Ч. Суман Д. Суман Н. Суман Т. Суман Б. Суман гэх зургаан Суман өглээд монгол байх ба ах Суман нь бусад 5 Сумнаан захирдаг байна.

Ойрд монголчууд хурим болоход заавал хуримын гийчийн ахлагч (толгойлогч)-г сонгон тогтоодог бөгөөд түүний тохируулгаар явагдадаг. Эдгээр нь нэг талаар овгийн байгууллын ахлагчийн эрх мэдэх есны ул мөр болох бөгөөд төрлийн ахлагч «гэвэл тухайн төрлийн дотооддоо хамгийн өндөр байр суурьтай байж, садан төрлийн бүх гишүүдийнхээ хүндэтгэлийг олдог. Энэ нь монголын эртний угсаа залгамжлах есны үлдэгдэл болж байна. Жишээлбэл дээд монголын аман аялганд «ахлагч» гэвэл толгойлогч, ах дүү, дээд: манай хүүхдүүдийн ахлагч нь их сургуульд явчлаа [Норжин, 1992, 383-р тал] гэх мэт. Монголын нийгмийн үе залгамжлах уламжлал нь овог буюу эцгийн шугамыг баримтлан нэг газар малжиж байсан ойрд монголчуудын дунд хадаглагдах нь яриангүй. Ойрд монголчуудын дотор нэгэн аавын олон хүүхдийн уу-

ган ах жич түүний ууган үр хойч нь энэхүү төрлийн төрөл сунжирах, төрөл алагших болтол ахлагчийн байр байдаг. Иймээс энэ төрөл дотор эцгийн ах жич түүний хүүхэд нь төрлийн бусад хүмүүстэй харицуулбал байр суурь нь өндөр болохоор хамтдан «авга» гэж хүндэтгэн дуудах болсон нь дамжиггүй. Энэхүү мөрдөлгийг «авга» гэх үгний бүтцээс ч мэдэж болно. Эрдэмтэн Г. Хайрхан, Б. Содийн «монгол хэл хийгээд монголчуудын уламжлалт соел» гэх номд авга гэх үг «аав + ах – абух ~ абуга – авга» болсон гэжээ [Хайрхан, 2001, 110-р тал]. Үүнээс үзэхэд «авга» гэх дуудлага нь ааваас эрх мэдэлтэй, байр суурьтай болох нь харагдаж байна.

Ойрд аялган дахь авга гэх дуудлага бол монголын эртний эцгийн эрхт гэр бүлийн ахмад хөвгүүн даруй ууган хөвгүүн өмч залгамжлах ба угсаа залгамжлах есноос илрэлттэй нэг зүйлийн төрлийн харьцааны дуудлага юм.

Ойрд аялганд эмэгтэй хүүхдийг нийт монгол хэлэнд нийтлэг хэрэглэгдэх «хүүхэн», «охин» гэж дуудхаас гадна «муу хөвгүүн», «жүгэр», «ноехон», «гилай / гилаан», «сэвгэр», «гээзгтэй», «нөхөөрэн» гэх мэт хэдэн зүйлээр дуудаж байна. Эдгээр дуудлага нь нийгэмийн хөгжилийн адил бус түүхэн цаг үед бий болж үүссэн бөгөөд гүн гүнзгий соелын агуулхуунтай байдаг.

Муу хөвгүүн. Ойрд монголчууд эрэгтэй хүүхдийг «сайн хөвгүүн» буюу «сайн» гэж үүний эсэргээр эмэгтэй хүүхдийг «муу хөвгүүн» буюу «жүгэр» гэдэг. Энэ нь өнгөрсний ойрдын ниигэм дэхь эрэгтэй эмэгтэйн тэгш бус нийгэмийн байр суурийн төрөлийн харьцааны дуудлага дахь тусгал болно. «Ойрд цагаач»-д нийгэмийн бүх гишүүдийг эрэмбэ дараалал, эд хөрөнгөөр нь «сайн, дунд, муу (адаг)» гэж хувиарлаж байсан ба эрэгтэй эмэгтэйн нийгэмийн байр суурийн тэгш бус байдал ч тусгагдсан байдаг. Жишээлбэл: 99-р зүйлд «боол эмээс гэрчид тоогүй» гэгчийг хажуугын тайлбарт «тайн болвоос эр боол гэрч болох эрхтэй байх естой... эр боол ба эм боолын адил бус байр суурийг илтгэж байна» [Донодаб, 1985, 169-р тал] гэжээ.

Гэр бүл бол нийгмийн үндсэн нэгж бөгөөд ниигмийн цомтгол дүрс мөн. Эрэгтэй эмэгтэйн ниигмийн байр суурийн хувирал нь гэр бүлийн дотоодод тусгалаа олох н лавтай байдаг. Ойрдод ураг салсан буюу бэлэвсэн бүсгүй ерөөс хүүгээ дагуулж хариад гарах ес байдгүй. Хүүгээ эцэгт нь эсвэл эцгийг нь садан төрөлд нь буюу суман элгэнд нь үлдээж, хүүхнээн эх нь авч явж болдог [Гомбо, 2004, 3-р тал]. Энэ нь эцгийн эрхт овгийн байгууллын угсаа залгамжлах уламжлал дахь хүү хүсч, хүүхэн гадуурхах үзэл нь ухамсрын үзэгдэл оршиж байсан болно. Монголчуудын дунд сая хүүхэдтэй болсон гэрийн хүнтэй уулзвал «эмээл хазаар тохох уу? товч шилбэ хадах уу?» гэж хүү хүүхэн аль нь болхыг лавладаг. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүний нийгмийн ажилын хувиарлалыг тусгаж байна. Шинжиан чохарчууд бол цэрэг гаралтай, эрэгтэйчүүд цэргийн алба хааж хил хязгаар сахих ниигмийн үүрэг чадал, ажилын хувиарлалтай холбоотой бөгөөд хүү гарвал цэргийн дансанд авж, гунан наснаас эхлэж сард гурван жин цагаан мөнгөн цалин өгдөг» [Гомбо, 2004, 8-р тал] бодит явдал нь эрэгтэй хүний нийгмийн байр суурь эмэгтэйчүүдээс өндөр болох бас нэгэн шалтгаан болж байна.

Ан агнуур, нүүдэл мал аж ахуй эрхлэн амьдарч байсан ба ахин дахин үүсэх дайны хөл үймээний дунд эрэгтэйчүүд нийгмийн гол тулгуур хүчин болж байлаа. Иймээс эцгийн эрхт овгийн байгууллын угсаа залгамжлах уламжлал ба нийгмийн ажлын хувиарлалд суурилсан феодалын ниигэмд «эрэгтэйг хүндэтгэж, эмэгтэйг хөнгөвчлөх» дүр төрх бий болсон «сайн

хөвгүүн ~ сайн» «муу хөвгүүн ~ жүгэр» гэх хүү охиноон дуудах дуудлага нь хэлний заншилын хүчиний нөлөөнд одоо болтол ойрд монголчуудын дунд яригдсаар байна.

«Нөхөөрэн хүүхэд — харид морьдсон хүүхэн» / «харваж гаргасан сум — хадамд өгсөн хүүхэн» / «хаданд цохигдсон чулуу» гэхчлэн Хубугсайрын торгууд монголчуудын хүүхэн үрээ дуудах нэг төрлийн дуудлага мөн. Энэ үг нь «нөгөө гэрийн» гэх бүтэцтэй, хэлний хэлхээндэх авиа товчлогдох жимээр гэ-үе товчлогдсон байна. Энэ нь монголын нийгмийн эхчлэлийн овог төрлөөс эхчлэлийн овог төрөлд шилжхийг дагалдан эмэгтэйчүүд эрэгтэйн талд хөөгдөн очих болсон хуримын зан үйл болно. Ойрдод эмэгтэйчүүд хурималхаасаа өмнө өөрийнхөө нэрний өмнө аавынхаа нэрээр тодотгол авч байсан бол хурималсны дараа өөрийнхөө нэрээр тодотгол авдаг заншил нь энэхүү ураг төрөл хийгээд хуримын ес жаягийн гүн гүнзгий нөлөө тусгалыг харуулж байх төдийгүй феодалын гэр бүлийн есондох эрэгтэй хүний эрх мэдэл сүр хүчийг харуулж байна.

Ноехон. Ойрд аялганд охин хүнийг хүндэтгэх буюу хөөрүүлэн дуудах дуудлага, жишээлбэл манай ноехон, танай ноехон г.м. Тус үг *ноен* + *-хан* бүтэцтэй байж, ноен язгуртны хүүхдийг дуудах буудлага байснаар үл барам эрэмбэ дараалал ялгалгүй нийгэмд хэрэглэгдэх болжээ. Эм хүйсийн ч багийг заах *-хан* / *-хэн* хэлбрээр илтгэж болно [兰司铁著, 1981, 270-р тал]. *-хан* / *-хэн* дагаварын утгын илэрэл хувьсалын тухай эрдэмтэн Ч. Дамдинсүрэнгээс «Хүү ба хөвгүүн гэдэг үгийн учир» гэх өгүүлэлдээ тодорхой ярьсан байдаг. Түүнээс «хүү» ба «хэү» авиа утгийн тохиролцоог нотолсон суурин дээр «хэү» гэдэг үгэнд «хэн» залгалтыг нэмээд анх «хэү»-г энхрийлэн дуудах утгатай байснаасаа аажмаар хүүхэн гэх утгатай болжээ» [Дамдинсүрэн, 1958, 88-р тал] гэв. Мөн эрдэмтэн Рамстедт «халимаг хэлэнд гэвэл ваны хөвгүүнийг заана» [兰司铁著, 1981, 60-р тал] гэжээ. Үүнээс зүйчилвэл, ойрд аялгандах «ноехон» гэх үг хамгийн анх вангийн хөвгүүн бага ноеныг зааж байснаасаа ноены хүүхдийг заах болж, одоо хүүхэд хүнийг хүндэтгэх буюу энхрийлэх утгаар хэрэглэх болжээ.

Сэвгэр~сэвгэрт~гээгтэй хуримлаагүй хүүхний дуудлага болно. Эртний монголчууд хүүхдийн гээг, эр хүний гээг, охины гээг, эхнэрийн гээг гэж тус тус ялгал бүхий гээг тавих естой байж билээ гэдэгчлэн эдгээр дуудлага нь монголчуудын гээг тавих ес, гээгний заслын улиран хувьсахтай холбоотой. «Монгол үгсийн язгуурын толь»-д *сэв(лгээ)* 1. гээгний хүндэтгэл, сэвлэгэр, сэвлгэр сэбэргэл ч гэдэг байжээ хоёр тэв гээг гурван хүүхдийн гээг; 2. (шил.) зарим ургамлын сахлаг үс сахал [Цэцэнцогт, 1988, 1519-р тал] гэх утгатай гэжээ.

Халхчуудын дунд хүүхдийн даахь (сэвлэгэ) авах «үсний найр» байдаг бөгөөд «...бүстэй хүүхдийн онгон сэвэлгийг бүгдийг нь авчих... бүс үгүй хүүхдийн даахиас (сонжоо) тавиж...» [Бадамхатан, 1990, 577-р тал] гэхээс үзвэл бүстэй хүүхэд ба бүстэй хүүхэд нь гээг үйлдэх эсгээрээ ялгаатай байна. Сэвлэгт~сэвлгэр гэж тухайн онцлогт харгалзуулан дуудах бол монголчуудын хэрэг бодисыг нэрлэх заншил ба монгол хэлний үг бүтээх есонд бүр зохицож байдаг. Монгол хэлэндэх *л~р* авианы сэлгүүцэл ба авианы тонгорлын жам есыг үндэсэлвэл ойрд аялган дахь сэвгэр ~ сэвгэрт гэх үгсийн бүрэлдсэн явцыг ойлгож болох юм.

Бүс үгүй хүүхдийн сонжоогоос 14~16 нас хүрэхээр нь тэв гээг, тэвэг (гол үс) тавиад 18~19 настайд нь их үс гээг «тавьдаг» [Бадамхатан, 1990, 578-р тал]. Хубагсайрын торгуудчуудын ярианд гээг гэвэл гавлын хойт талын хэсэг буюу тэр хэсэгт ургасан урт үсийг заадаг. Хүүхэн хүүхдэд наян найман гээгтэй гэж хэлэх нь бүсгүй хүүхдийн бүстэй хүүхдээс ялгагдах бас нэгэн онцлог болж байна. «Палан Карбины жуучлалын тэмдэглэл», «Вилиам Рүбрэгийн жуучлалын тэмдэглэл», «Чэнчүн бумбын баруунд аялсан тэмдэглэл»-д эрэгтэйчүүд бүр хоер салаа хэсэг гүрдэг гэх мэдээтэй байх ба Норжин, Чойдандар нарын «Нутгийн аялгын үгсийн хураангуй»-д «гээг — охид ба харчуулын ардаа ганц гүрсэн үс. Авгай хүний хувааж гүрсэн үсийг гээг гэхгүй, үс л гэнэ» [Норжин, 1992, 425р-тал] гэжээ. Иймээс ойрд аялган дах гээг гэх дуудлага бол эрэгтэй хүн охор үс тавих болсон ба эхнэр хүн гэзгээн хувааж гүрэх болсон үед бий болсон дуудлага болно.

Сэвгэр ~ сэвгэрт ~ гээгтэй гэх дуудлагад монголчуудын гээг тавих ес ба гээгний заншлын зан үйлийн улиран хувьсалын ул мөр харагдаж байхыг гаргавал бусад ямарч сэтгэлгээний өнгө будаг байхгүй юм. Энэ нь эрэгтэй, эмэгтэйн нийгмийн байр суурь эрх тэгш болсон цаг үед бий болсон дуудлага болно. Феодалын нийгэмд баяд, ноёд, язгууртан, тайж нарын авхай хүүхдийг дуудаж байсан ноёхон, гялай ~ гялган (гэрэл гялбаа гэх утгатай) гэх мэтийн дуудалгыг анги давхаргын ялгаагүйгээр хүүхэд хүнд нийдэм хэрэглэх болсон нь эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийн дээшилснийг хариулж байна.

Нийгмийн хөгжилийг даган баяд, ноёд язгууртанд хэрэглэгдэж байсан дуудалгын үг одоогийн ойрд аялганд нэгэнт зэрэг дэсийн ялгаагүйгээр хүндэтгэлийн утгаар буюу энгийн утгаар түгээмэл хэрэглэгдэж байна. Жишээлбэл, «Жангар»-т: авхай — хатан, хатагтай, ноентон эрхэм язгууртны гэрийн эзэн бүсгүй: абай гэрэл хатан г.м. Энэ үг ойрд аялганд ээжээ гэж дуудах дуудлага болжээ. Агаа — хатан хатагтай, гэргий: ойрдын ерөөлөөр учирсан агаа ноён г.м. Мөн «Ойрд цагаач»-н 13-р зүйлд «Их ноён агаа чилээрхлээ» гэх мэтээр агаа гэх үг нь бүр ноён гэх үгтэй хоршин илэрч байжээ. Энэ үг одоогийн ойрд аялганд эгчмэд хүнийг хүндэтгэн дуудах дуудлага болсон байна. Дээр ярьсан шигээр ойрд аялган дахь «муу хөвгүүн», «жүгэр», «ноёхон» мэтийн хүүхэн хүнийг дуудах дуудлага үгст эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийн хувиралт маш ил тодорхой тусгагдаж байна.

Төрөл садны дуудлага бол нийгмийн хөгжилийн адил бүх үе шат дэх ураг хурмын дүрэм жич түүний суурилсан гэр бүлийн харьцааны тусгал болно. Гэхдээ тэр нь ураг хуримын заншил ба гэр бүлийн хэлбрээс харьцангуй тогтвортой байж, тэрхүү дуудлагыг бии болгосон тухайн цаг үеийн соелын агуулуунаа урт удаан хугацаанд хадгалагдан үлдсэн байдаг.

Ойрд аялганы төрөл садны дуудалгын систем нь ерөнхийдөө аймаглал ба тодорхойлол маягийн холимог шинжтэй байдаг. Үүнд аймаглал маягийн төрөл садны дуудлагад монголын эртний ураг хуримын заншил улиран гүн гүнзгий хадгалагдан үлджээ. Энэ маягийн дуудлагад нагац, жих, худ, авга, ач, хүргэн, бэргэн, бэр гэх мэт олон байна.

Нагац — «хүний эх нь нагац, усны эх нь булаг», «нагацын шар нохой ахлана» гэж, эх эмэг жич түүнээс дээд үеийн эмэгтэй дээдсийг хамааруулан дуудах дуудлага болно. «Зэх» өөрийн хүүхэн жич түүнээс доод үеийн хүүхэн. Эгч хүүхэн дүүгийн хүүхэн. Авга эгч жич түүнээс дээд үеийн эмэгтэй дээдсийн үр хүүхдийг хамааруулан дуудах дуудлага болно. Худ, худгай — эл

үеийн хүргэдийн төрөл ба бэрдийн төрхмийг хамтруулан уудах дуудлага болно. Ойрд аялганд чохар аман аялага ба тэгсийн дөрвөн суман шавь нарын ярианд худ гэхгүй харин худгай гэдэг. Урагийн хоер тал харилцан худгай гэх бөгөөд ураг тогтхыг худгай болох гэдэг.

Ойрд аялганд яагаад эцгийн талын гол хэлхээний төрлийн харилцаанд нэг нэгний харгалзсан дуудлага байхад, эхийн талын төрлийн харилцаанд аймаглал маягын төрөл садны дуудалгаар голлон үзэж нас ялгадаггүй вэ? Энэ тухай эрдэмтэн Д. Гонгор «ураг төрлийн эцгийн талын авга, ач есөн үе уламжилж цайн хадгалгдсан байхад, нагац зэхийн хэлхээ холбоо үлэмж богиноссон нь... Нэг, эхийн эрхэт есон бол хүний нийгмийн анхны элэр балар үе болохын учир ул мөр түрүүнд арилж улирах нь лавтай. Хоерт, бидний мэдэж байгаагаар монголын нийгэмд эцгийн эрхт феодалын харилцаа мянга гаруй жилийн өмнөөс ноерхож эхэлсэн нь эхийн эрхт есны улбааг улам бүдгэрүүлж үгүйсгэх гол шалтгаан болжээ» [Гонгор, 1983, 23-р тал] гэж үзсэн байна.

Манай үзсэнээр энэхүү аймаглал маягын нагац, зэх, худ мэтийн төрөл садны дуудлага нь эрдэмтэн Д. Гонгорын дүгнэсэн хоер зүйлийн шалтгаанаас гадна, эртний монголчуудын овгын гадна ураглах ураг хуримын ес заншил ба үе хутгалдан хуримлах ураг хуримын заншлаас үндэс сурвалжтай болно. «Монголын бүх овог буюу овогт нийгэм ураг, харь хэмээн хоер үндсэн хэсэгт хуваагдана» [Гонгор, 1983, 24-р тал] гэсэн ба «Зэдийн дотроо түргүд тухайлбал (гэргийн талын төрөл садан) болох овог буюу овог төрлүүд ба аймгийн салбар багтаж байдаг. Иймэрхүү овгийн гишүүнийг жинхэнэ жидээр үздэггүй, харин худ гэж хүндэтгэн нэрэлдэг байна» [Владимирцов, 1980, 124-р тал] гэсэн нь ил тодорхой овгийн гаднах хуримлах есны тайлбар болж байна.

«Эртний үеийн нэг овгууд нь овгоороо нэг дор маллах бололцоотой байсан үед, бүх овгийн төрөл саднаар эсвэл хамт нийтээрээ нэг хүрээ буудаладаг» [Владимирцов, 1980, 129-р тал]. Иймэрхүү аж ахуйн амьдрал нь овог төрлийн хоорондох харилцааг нягтруулж, эцгийн шугамыг баримталсан овгийн дотоодын төрлийн харилцааны дуудалгыг олшруулхад, эхийн шугам — алс хол харь нутгаар амьдрах нагацын системийн төрөл садны дуудлага харьцангуй цөөхөн боолын нэг шалтгаан болж байна. Хэл бол хүмүүсийн харилцааны багаж мөн. Харилцааны агуулага нь хэлийг тогтоодог. Иймэрхүү нагац зэхийн урт хугацаагаар харилцахгүй бодит нөхцөл нь тэдний хоорондох үе, нас ялгах шаардлагагүй бөгөөд түүнийг ялгах нь ч хэцүү байдаг.

Нөгөө талаар үе хутгалдан ураглах ургийн хэлбэр нь ч эдгээр нэрийдлийн нарийсч чадахгүйн бас нэг шалтгаан болно. Жишээлбэл: Чингис хаан ба түүний хөвгүүн Зүчи, Тулуй тус бүр Хэрээдийн Ван хааны ач хүүхэнтэй хурималсан [拉施特, 1985, 215-р тал], ойрдын Хутга бэхийн хоер хөвгүүн Дөрөлч, Иналч тус бүр Чингис хааны охин Цэцхэн ба Зүчийн хүүхэн Хуланхантай хурималсан [拉施特, 1985, 195-р тал], ойрдын эцэг Тайшын эгч монголын хан Тогтобөхтэй хурималсан жич эсэний хүүхэн дүү нь Тогтохбөх ба энэхүү эгчээс гарсан хүүтэй хурималсан [都兴智, 1994, 67-р тал] зэрэг тэмдэглэл нь эрт цагийн монголчуудын үе хутгалдан хуримлах заншил ойр үе болтол ойрдын дунд үлдэгдэж ирснийг харуулж байна. Даруй энэхүү ураг хуримын заншил дүрэм нь тухайн үед нагац зэргийн хооронд үе ялгах нийгмийн суурийг бүрдүүлж чадахгүй мөртөөн хүргэн, бэр-ийн хооронд ч үе ялгаж чадахгүй байдаг. Үүнийг «Монголын нууц товчоо»-ны 202-р зүйлд бух хүргэн, бод хүргэн, алч хүргэн, онгодын алхуш дигид хори хүргэн... [Элдэн-

тэй, 1986, 661-р тал] зэрэг үе ялгалгүй хүргэн гэж дуудаж байсан уламжлал одоогийн ойрд монголчуудын дунд хадгалагдсаар байна. Ойрд аялгад авга эгчийн хүргэн, эгчийн хүргэн, нагац эгчийн хүргэнийг бүр хүргэн ах гэж дуудах ба хүүхэн дүүгийн хүргэн, ач хүүхний хүргэн, зээ хүүхний хүргэнийг бүр хүргэн хөвгүүн гэж дууддаг. Үүнтэй харгалзаад авгын эхнэр, ахын эхнэр, нагацын эхнэрийг бүр бэргэнгэж дүүгийн эхнэр, хүүгийн эхнэр, ачийн эхнэр, зээгийн эхнэрийг бүр бэр гэж дууддаг. Үүнд нэлээд олон эрдэмтдээс монгол хэлний хүргэн, бэргэн, бэрээрэг төрөөл садны дуудалгыг шинжлээд хүргэнгэх үг бол эхчлэлийн овог төрөлийн үеийн «хүүгээ хүүхний талд хүргэж байсан» ургийн есны ул мөрийг харуулж байна гэжээ. Бэр гэх үг бол бариж авах гэсэн утгаас үүсэл бүхий эхчилэлийн овог төрлийн «булаах ураг»-н үр дүнд бий болсон юм. Бэргэнгэх үг бол бэр гэх үгээс гарал нэгтэй байж, эртний монголчуудын «залган ураг»-ийн бүтээгдхүүн мөн [哈斯巴特尔, 1994, 83-р тал] гэсэн ба худгэх үгээс зүйчилэн эртний монголын нийгэмд худалдаанд ураг байсан [文英, 2003, 23-р тал] зэрэг дүгнэлтийг гаргасан юм.

Гэр бүл бол бүхэл нийгмийн цомотгол дүрс мөн, нийгмийн хөгжил хувирал нь гэр бүлийн есонд тусгагддаг. Ойрд монголчуудын төрөл садны дуудлагад овгийн байгууллаас эхтэй эл цаг үеийн нийгмийн байгууллын угсаа залгамжлах, өв залгамжлах, эзэмших эрх хийгээд хүмүүсийн нийгмийн байр суурийн хувирал, ураг хуримын есны улиран хувьсалын ул мөр хадгалагдаж байна.

Ном зүй

1. Бадмагтан С. нар. Бүгд найрамдах монгол ард улсын угсаатны зүй. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1990.
2. Владимирцов Б. Я. Монголын нийгмийн байгууллын түүх. Үндэстний хэвлэлийн хороо, 1980.
3. Гомбо Г. Шинжианы монголчуудын зан үйл (тод үсэг). Шижиан шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2004.
4. Гонгор Д. Халх монголчуудын ураг төрлийн тогтолцоо. Оюун түлхүүр, 1983.
5. Гонгор Д. Халх товчоон. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1990.
6. Дамбижалсан Г. Монгол зан үйлийн зүй. Ляонин үндэстний хэвлэлийн хороо, 1995.
7. Дамдинсүрэн Ч. Хүү ба хүүхэн гэдэг үгийн учир // Монгол хэл зохиол түүх. 1958. 8-р хугацаа.
8. Донодаб. Ойрд цагаач. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985.
9. Норжин Ц., Чойдандар. Нутгийн аялаганы үгсийн хураангуй. Үндэстний хэвлэлийн хороо, 1992.
10. Хайрхан Х., Сод Б. Монгол хэл хийгээд монголчуудын уламжлалт ес. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2001.
11. Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1988.
12. Элдэнтэй, Арджав. Монголын нууц товчоо. Сийрүүлэл тайлбар. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986.
13. 兰司铁著《陈伟等议》. 阿尔泰语言学导论. 中国社会科学出版社, 1981.

14. 拉施特《史集》第一卷。第一分册，商务印书馆，1985。
15. 都兴智《明代蒙古人的婚俗》，《北方民族》1994年第2期。
16. 哈斯巴特尔《从蒙古语〈女婿〉〈媳妇〉程未来源看婚俗的变迁》，《内蒙古大学学报》1994年第1期。
17. 文英《论蒙古族亲属称谓中所反映的民族文化现象》西北民族学院学报 2003年第1期。

THE CULTURAL CONNOTATION OF KINSHIP WORDS IN OIRAD DIALECT

Soyol

Inner Mongolia University
235, East University Rd, Huh-hot, China

Oirad Mongolian kinship words system is not only one of the most important parts of Oirad Mongolian lexicon, but also the cultural words that could denote the unique feature of Oirad Mongolian society and culture. This paper aims to introduce the distinctive feature and cultural connotation of Oirad Mongolian kinship words through the analysis of kinship words in Oirad Dialect. But all of these seasons has accrued during the deep cultural content transformations reflect the long history of content and find fulfillment through a variety of characteristics relatives to travel. In the words of an article recently selected features Mongolian relatives accent, shinjilev season move through the process of evolution in the history of its cultural content recently Mongolian tribal society to society, in terms of feudal society and society.

Keywords: Oirad dialect; kinship words; cultural connotation; word system; sign; history; feudal; society; family; transformation.